



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВД

**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2025.01.07 № 1/24
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2024 оны “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний тайлан, “Хэрэглэгчийн үнэлгээний дагуу хэрэгжүүлсэн ажлын тайлан”-г хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 54 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.БЯМБАСҮРЭН

142250046



2024 ОНЫ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

Зорилго:

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн амбулаториор үйлчлүүлэгч нарыг судлан, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах, шаардлагатай асуудлыг шийдвэрлэн, зохих арга хэмжээг авч ажиллах

Зорилт:

- Байгууллагын хөгжил, удирдлага зохион байгуулалтыг сайжруулахад нотолгоо болгон ашиглах
- Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг байгууллагын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд шаардлагатай нотолгоонд суурилсан мэдээллээр хангах

Судалгааны үргэлжилсэн хугацаа:

2024 оны 1 дүгээр сараас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд.

ЭМС-ын А/346 тоот тушаалын хүрээнд авсан судалгаа:

Уг сэтгэл ханамжийн судалгааг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1041 тоот дугаар албан бичгийн дагуу “Журам шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2022 он А/346 дугаар тушаалын дагуу улсын хэмжээнд хэрэглэгчийн нэгдсэн үнэлгээг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн цахим хэлбэрээр зохион байгуулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран хэрэглэгчийн асуумжийн QR кодыг үүсгэн амбулаторийн хүлээлгийн танхим болон хэвтүүлэн эмчлэх тасгийн эмчлүүлэгчийн өрөө, сувилагчийн постод тус тус байршуулсан судалгааг авав.

- | | |
|-------------|--|
| ХАВСРАЛТ 1. | Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдээс авах сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн тайлан |
| ХАВСРАЛТ 2. | Амбулаторийн буй үйлчлүүлэгчдээс авах сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн тайлан |

УНТЭ-ийн ЭМТҮЧАБА, ХНХА-аас боловсруулсан асуумжийн дагуу авсан судалгаа:

- | | |
|-------------|--|
| ХАВСРАЛТ 3. | MNS 7014:2023 стандартын дагуу амбулаторийн тусламж үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн тайлан |
| ХАВСРАЛТ 4. | Эмчилгээний хоолны сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн тайлан |
| ХАВСРАЛТ 5. | Ажилчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн тайлан |

**Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн
судалгааны үр дүнгийн тайлан**
/ЭМС-ын 2022 он А/346 дугаар тушаал/


Материал, арга зүй:

- Судалгаанд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ГЭТ, БТ, ЦЭСЧШСТ, ЗТ, УЭСТ, ДШСДТ, МЭТ, ЕМЗТ, УАТ, ЭШСТ, ХҮСҮСТ, БШГМЗТ, ЧХХСТ, ЭНМЗТ, НЭСМЗТ, тасаг, нэгжүүдэд хэвтэн эмчлүүлж буй 272 үйлчлүүлэгч нар хамрагдлаа.
- Эрүүл мэндийн хөгжийн төвийн 2022 оны 12 сарын 07-ны 1041 тоот албан бичгийн дагуу үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны QR кодыг хэвтэн эмчлүүлэх тасаг нэгж бүрийн сувилагчийн постны дэргэд байршуулсан.



1. Эмч эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг зөвлөснөөс хойш хэдий хугацааны дараа эмнэлэгт хэвтсэнийг хугацаагаар харьцуулсан нь

**Хэвтэн эмчлүүлэх шаардлагатай гэж эмч зөвлөснөөс хойш та
хэр хугацааны дараа эмнэлэгт хэвтсэн вэ?**




2. Эмнэлэгт хэвтэхийн тулд хэн нэгнээр яриулах, шан харамж төлөх шаардлага байсан эсэх

Та энэ удаад эмнэлэгт хэвтэхийн тулд хэн нэгнээр яриулах, шан харамж төлөх шаардлага байсан уу?



3. Хэнээс туслалцаа авсан байдлаар харьцуулсан нь

■ Ах дүү, төрөл төрөгсөд, найз нөхдөөрөө яриулсан ■ Шан харамж төлж байж эмнэлэгт хэвтсэн



4. Эмч өдөр тутам үзлэг хийсэн эсэхийг харьцуулсан байдал




5. Эмч мэндэлсэн эсэхийг харьцуулсан байдал




6. Эмч анхааралтайгаар сонссон эсэх

Эмч таныг анхааралтай сонсож байна уу?



7. Эмтэй холбоотой илэрч болох гаж нөлөөний талаар эмч танд хэлж анхааруулсан

Эмтэй холбоотой илэрч болох гаж нөлөөний талаар эмч танд хэлж анхааруулсан уу?



уу?


8. Сувилагч нар мэндэлсэн эсэхийг харьцуулсан байдал

Сувилагч нар тантай мэндэлдэг үү?

■ Тийм

■ Үгүй

■ Зарим сувилагч
нар мэндэлдэг



9. Сувилагч эмчилгээ хийхийн өмнө гараа тогтмол халдваргүйжүүлдэг эсэх байдлаар


Сувилагч танд эмчилгээ хийхийн өмнө гараа тогтмол халдваргүйжүүлдэг үү?

■ Тийм

■ Би анзаараагүй

■ Тогтмол биш


■ Үгүй



10. Сувилагч нар эмчилгээг / цагийн тариа, дусал хийх, эм тараах гэх мэт/ хугацаанд нь хийсэн байдлаар харьцуулсан

Сувилагч нар эмчилгээг (цагийн тариа, дусал хийх, эм тараах) хугацаанд нь хийж байна уу?


■ Тийм ■ Үгүй ■ Голдуу хоцордог



11. Сувилагч нар анхааралтайгаар сонсдог эсэх байдлаар харьцуулсан

Сувилагч нар таныг анхааралтайгаар сонсдог уу?

■ Тийм ■ Үгүй



12. Эмнэлгийн асрагч мэндэлдэг эсэх байдлаар харьцуулсан

Эмнэлгийн асрагч тантай мэндэлдэг үү?

■ Тийм

■ Үгүй

■ Зарим сувилагч нар л мэндэлдэг



13. Асрагч нар үйлчлүүлэгчдийн хэвтэж буй өрөөний цэвэрлэгээг өдөр тутам хийдэг эсэх байдлаар харьцуулсан

Асрагч нар таны хэвтэж буй өрөөний цэвэрлэгээг өдөр тутам хийж байна уу?

■ Тийм

■ Хааяа

■ Үгүй



14. Эмнэлэгт хэвтэхдээ орны даавуугаа гэрээсээ авчирсан эсэх

Та эмнэлэгт хэвтэхдээ орны даавуугаа гэрээсээ авчирсан уу?




15. Үйлчлүүлэгчдийн орны даавуу бохирдсон үед эмнэлгээс сольж өгсөн эсэх байдал

Таны орны даавуу бохирдсон үед эмнэлгээс сольж өгсөн үү?

■ Тийм

■ Үгүй


■ Шаардлага үүсээгүй



16. Эмнэлэгт хэвтэх хугацаанд гаднаас эм тариа, марьл, бинт, мэс заслын утас гэх мэт эмчилгээнд хэрэгтэй зүйлс авчруулахыг эмчийн зүгээс үйлчлүүлэгчидэд зөвлөсөн эсэх

Эмнэлэгт хэвтэх хугацаанд гаднаас эм тариа, марль, бинт, мэс заслын утас гэх мэт эмчилгээнд хэрэгтэй зүйлс авчруулахыг эмчийн зүгээс танд зөвлөсөн үү?


■ Тийм ■ Үгүй ■ Эмч зөвлөөгүй, гэхдээ би өөрийн хүсэл сонирхлын улмаас нэмэлт зүйлс авчруулсан



17. Үйлчлүүлэгчид гэрээсээ хоол зөөлгөх шаардлага байсан эсэх

Танд гэрээсээ хоол зөөлгөх шаардлага байсан уу?

■ Тийм ■ Үгүй




18. Эмнэлэг чимээ шуугиан ихтэй байсан эсэх

Эмнэлэг чимээ шуугиан ихтэй байсан уу?

■ Тийм

■ Үгүй




19. Тасгийн ариун цэврийн өрөө /ОО/ цэвэрхэн байсан эсэх

Тасгийн ариун цэврийн өрөө /ОО/ цэвэрхэн байна уу?

■ Тийм

■ Үгүй

■ Ихэнхдээ бохир байдаг



20. Эмнэлэгт хэвтэх хугацаанд танд үзүүлж буй тусламж үйлчилгээнд хэр сэтгэл хангалуун байгаа эсэх

Энэ удаад та тус эмнэлгийн үйлчилгээнд хэр сэтгэл хангалуун байна вэ?



21. Эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг сайжруулахад юунд анхаарах шаардлагатай байгаа талаарх саналаа хүсэлтээс дурдахад:

- Тоног төхөөрөмжөө хүрэлцээтэй болгох /тэргэнцэр, монитор, хөнжил, орны бүтээлэг, тарианы тэргэнцэр, ор бүрийн тоогоор шкаф, сэнс, агааржуулагч, разетка/
- Өвчтөнтэйгөө эмч сувилагч нар тулж ажиллах
- Сувилагч нарын харилцаа муу байна.
- Хоолны хэмжээ бага байна, хоол зөөдөг ажилтны харилцаан дээр анхаарах
- Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ муу байна. Ариун цэврийн өрөөний суултуур жижиг.

- Дархлаа дарангуйлах эмийн хэрэглээтэй өвчтөнүүдийг бусад өвчтөнүүдээс тусгаарлах хэрэгтэй байна. Энгийн хүмүүс тогтмол орж гардаг, хүмүүстэй чөлөөтэй уулздаг тул халдвар тараах эрсдэл өндөр байна. Ялангуяа томууны улиралд.
- Үндсэн эмч, резидент эмч болох эсэх тодорхой бус яг аль эмч нь хариуцаж үзэж байх, эм тариа, боолт хийж байх, анхаарах эсэх нь тодорхой бус ойлгомжгүй, өөрөө асууж байнга лавлах хэрэгтэй болдог Хагалгаанаас бус өөр өвдөлт, хүндрэлд эмч нар анхаарахгүй, тоохгүй үлдээж байна.
- Эмч, резидент эмч, сувилагч, асрагч эсэх нь тодорхой бус байдагт анхаарах
- Зарим зөвлөмжийг харааны бэрхшээлтэй хүмүүст олж уншихад хялбар байхаар том фонтоор бичих.
- Хэвтэн эмчлүүлэгч нарын журам гаргаж тавих, нэгэндээ их саад болдог.

Судалгааны үр дүн:


- Хэвтэн эмчлүүлэгсдийн 33,5% шууд хэвтэж, 29,8% нь 1-3 хоногтоо багтаад эмнэлэгт хэвтэж байна. 26,8% нь 4-14 хоногтоо, 9,9% нь 14 хоногоос дээш хугацаагаар орны хүлээгдэлтэй байна. Үүнээс дүгнэхэд үйлчлүүлэгчдийн 63,3 хувь нь эхний 3 хоногтоо багтан хэвтэн эмчлүүлж байгаа нь манай эмнэлгийн орны хүлээгдэл их байгааг харуулж байна.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ашиг сонирхлын байдлыг дүгнэхэд 93% үгүй гэсэн хариулт өгсөн байна.
- Эмч нарын ажлын хариуцлагыг дүгнэхэд:
 - Дунджаар 89,3% дээш эмч өдөр бүр үзлэг хийдэг.
 - Дунджаар 95% үйлчлүүлэгчтэй мэндэлдэг.
 - 97,4% үйлчлүүлэгчийг анхааралтай сонсдог.
 - 94,5% эмтэй холбоотой илэрч бодох гаж нөлөөний талаар хэлж анхааруулдаг гэж дүгнэсэн байна.
- Сувилагч нарын талаарх асуумжаар:
 - Дунджаар 93,7% үйлчлүүлэгчтэй мэндэлдэг.
 - Дунджаар 90-ээс дээш хувь эмчилгээ хийхийн өмнө гараа тогтмол халдваргүйжүүлдэг.
 - 95% сувилагч нар эмчилгээгээ хугацаандаа хийдэг.
 - 96,3% үйлчлүүлэгчийг анхааралтай сонсдог.
- Асрагч нарын талаарх асуумжаар:
 - Дунджаар 87,5% үйлчлүүлэгчтэй мэндэлдэг.
 - Үйлчлүүлэгчдийн 97,4% нь асрагч нар үйлчлүүлэгчийн өрөөний цэвэрлэгээг өдөр бүр хийдэг.
 - Тасгийн ариун цэврийн өрөө хувьд 86% цэвэрхэн байдаг, 14% бохир байдаг гэж дүгнэсэн байна.
- Үйлчлүүлэгчдийн 85% эмнэлэгт хэвтэхдээ орны даавуугаа гэрээсээ авчирсан бөгөөд үйлчлүүлэгчдийн 23% орны даавуу бохирдсон үед сорьж өгөөгүй гэж санал өгсөн.

- Эмнэлэгт хэвтэх хугацаанд гаднаас эм тариа, марль, бинт, мэс заслын утас гэх мэт эмчилгээнд хэрэгцээтэй зүйлсийг авчруулахыг 32% хэлсэн, 13% өөрсдийн санаачилгаар авчирсан гэж санал өгсөн.
- Үйлчлүүлэгчдийн 45% гэрээсээ хоол зөөлгөх шаардлагатай байсан.
- Үйлчлүүлэгчдийн 30% эмнэлэгт чимээ шуугиан ихтэй байсан гэж дүгнэсэн.
- Хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий дундаж /0-5/ оноогоор үнэлэхэд 89.7% байна.


Харьцуулсан үзүүлэлт, шинжилгээ

Үйлчлүүлэгчийн ерөнхий сэтгэл ханамж өмнөх онтой харьцуулахад 6,9%-өссөн үзүүлэлттэй байна.

Үйлчлүүлэгчийн эмнэлгийн үйлчилгээнд хэр сэтгэл хангалуун байгааг 2023 оны үзүүлэлттэй харьцуулахад



Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн харьцуулсан үзүүлэлт



Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт.

Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж 89,5% байна.

1. Орны хүлээгдлийг бууруулах арга хэмжээ авах.
2. Сувилагч нарын ажлын ачааллыг 1 ажилтанд ноогдох бодит байдлыг тодорхойлон дүгнэж, шаардлагатай бол нэмэгдүүлэх арга хэмжээ авах
3. Үндсэн эмч, сувилагч, суралцагч эмч тус бүрийг ялгагдах нөхцөлийг бүрдүүлэх. Энгэрийн тэмдэг, мэсийн хувцас болон халаадаар ялгах.
4. Тасгуудын ОО өрөөний цэвэрлэгээ, хангамжийг сайжруулах
5. Хэвтэн эмчлүүлэгчийн дотоод журмыг үйлчлүүлэгч бүрийг хэвтэхийн өмнө танилцуулж байх, зөвлөмж журмыг үйлчлүүлэгчид харагдахуйц байдлаар байрлуулах.
6. Эмчилгээний хоолны чанар, хэмжээнд хяналт хийж сайжруулах
7. Эмч сувилагч нарын харилцаа хандлагыг сайжруулах
8. Сувилагчийн тэргэнцрийн дуу чимээг багасгах тал дээр ажиллах
9. Палатуудын разетканы тоог нэмэгдүүлэх, ор бүрд тусдаа шкафыг хийх, хөнжил бүтээлгийг солих, шаардлагатай тасгуудад урсгал засвар болон тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах


Амбулаторийн буй үйлчлүүлэгчдээс авах сэтгэл ханамжийн

судалгааны үр дүнгийн тайлан

/ЭМС-ын 2022 он А/346 дугаар тушаал/


Материал, арга зүй:

2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар судалгаанд Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн амбулатороор үйлчлүүлсэн 346 үйлчлүүлэгч хамрагдсан.




1. Эмнэлэгт хөтөч байдгийг мэдэх эсэх

Энэ эмнэлэгт хөтөч байдгийг та мэдэх үү?




2. Эмнэлгийн хөтчийн туслалцаа авсан эсэх

Та энэ удаа эмнэлгийн хөтчийн туслалцаа авсан уу?




3. Хөтчийн чиглүүлсэн байдал нь оновчтой байсан эсэх

Хөтчийн чиглүүлсэн байдал оновчтой байсан уу?




4. Эмнэлэгт үзүүлэх цаг захиалсан эсэх

Та энэ удаад эмчид үзүүлэх цаг захиалсан уу?




5. Эмчид үзүүлэх цаг хэрхэн захиалсан байдлаар харьцуулахад

Та ямар шугамаар эмчид үзүүлэх цаг захиалсан вэ?



6. Хэр хугацааны дараа эмчид үзүүлэх цаг товлогдсон байдлаар харьцуулахад


Таньд хэр хугацааны дараа эмчид үзүүлэх цаг товлогдсон вэ?



7. Товлогдсон цаг үйлчлүүлэгчдийн үзүүлэхийг хүсэж байсан хугацаанаас хэр зөрүүтэй байсан эсэх байдлаар харьцуулсан

Товлогдсон цаг нь таны үзүүлэхийг хүсч байсан хугацаанаас хэр зөрүүтэй байсан вэ?


- Бодсоноос илүү удаан хүлээх шаардлагатай болсон
- Өөрийн хүсэж байсан хугацаандаа үзүүлэх цаг захиалж чадсан



8. Товлогдсон цагтаа эмчид үзүүлж чадсан эсэх байдлаар харьцуулсан

Та хүлээлгүйгээр товлогдсон цагтаа эмчид үзүүлж чадсан уу?

■ Тийм ■ Үгүй



9. Эмчид үзүүлэх товлөгдсон цаг өнгөрснөөс хойш хэр удаан хугацааны дараа үзүүлсэн байдлаар харьцуулсан


Эмчид үзүүлэх товлөгдсон цаг өнгөрснөөс хойш хэр удаан хүлээсний эцэст та эмчид үзүүлж чадсан вэ?



10. Эмч мэндэлсэн эсэхийг харьцуулсан байдал

Эмч тантай мэндэлсэн үү?


■ Тийм ■ Үгүй



11. Эмч үйлчлүүлэгчдэд үзлэг хийхийн өмнө гараа халдваргүйжүүлсэн эсэх

Эмч танд үзлэг хийхийн өмнө гараа халдваргүйжүүлсэн үү?


■ Тийм ■ Үгүй ■ Анзаарсангүй



12. Өвчний онош, хийгдэх шинжилгээ болон эмчилгээний талаар эмч үйлчлүүлэгчдэд ойлгомжтойгоор тайлбарласан эсэх

Өвчний онош, хийгдэх шинжилгээ болон эмчилгээний талаар эмч танд ойлгомжтойгоор тайлбарлаж өгсөн үү?


■ Тийм ■ Үгүй



13. Эмтэй холбоотой илэрч болох гэж нөлөөний талаар эмч үйлчлүүлэгчдэд анхааруулсан эсэх

Эмтэй холбоотой илэрч болох гэж нөлөөний талаар эмч танд хэлж анхааруулсан уу?


■ Тийм ■ Үгүй



14. Эмч үйлчлүүлэгчдийг анхааралтайгаар сонссон эсэх

Эмч таныг анхааралтай сонссон уу?


■ Тийм ■ Үгүй



15. Үйлчлүүлэгч сувилагчтай харьцсан эсэх


Та сувилагчтай харьцсан уу?

■ Тийм ■ Үгүй



16. Сувилагч үйлчлүүлэгчийг анхааралтайгаар сонсож байгаа эсэх

Сувилагч таныг анхааралтайгаар сонсож байна уу?



17. Эмнэлгийн үйлчилгээнд хэр сэтгэл хангалуун эсэх байдлаар харьцуулсан



18. Амбулаторийн үйлчлүүлэгч нараас судалгаанд бичгээр дамжуулсан санал хүсэлтээс дурдахад:

- Цагтаа эмх цэгцтэй үзлэгтээ орох
- Сувилагч болон цахим бүртгэлийн ажилчдын харилцааг сайжруулах, маш бүдүүлэг байна
- Оочир их байна.
- Хөдөө орон нутгаас ирж байгаа үйлчлүүлэгч нарт олон хоногийн дараах шинжилгээний цаг болон давтан үзлэгийн цаг маш их чирэгдэл үүсгэж хүнд байдалд оруулж байна.
- Эмч нар ажлын цагаар өрөөгөө орхин явах асуудал, цайны цагаасаа гарч ирдэггүй их хүлээлгэдэг,
- Битүүмжийн асуудал үнэхээр хэцүү байна.
- 413 өрөөний сувилагч харьцааны асар доголдолтой.
- Цусны тасагт хими эмчилгээ хийлгэх хүмүүсийн стори нээх гэж шат дамжлага хүнд суртал үнэхээр их байна. Өглөө 09 цагаас хойш явсаар 11:20 д түүхээ нээлгэх гээд хүлээсээр л сууна
- Хөтөч сайжруулах


Судалгааны үр дүн:

- Үйлчлүүлэгчдийн тал хувь нь эмнэлэгт хөтөч байдгийг мэддэггүй бөгөөд нийт үйлчлүүлэгчдийн 40% нь хөтчийн тусламжийг авсан байна. Хөтчийн туслалцаа авсан үйлчлүүлэгчдийн 92% үйлчилгээг оновчтой байсан гэж дүгнэсэн байна.
- Үйлчлүүлэгчдийн дүгнэлтээр эмч нарын үйлчлүүлэгчтэй мэндлэх, угтах үйлчилгээ болон үйлчлүүлэгчийг анхааралтай сонсох ур чадвар /66% эмч үйлчлүүлэгчтэй мэндэлсэн, 84% эмч үйлчлүүлэгчийг анхааралтай сонссон, 77% сувилагч үйлчлүүлэгчтэй харилцсан, 86% сувилагч үйлчлүүлэгчийг анхааралтай сонссон/ - ийг дүгнэхэд эмч сувилагч нарын харилцаа хандлага дундаж байна.
- Үйлчлүүлэгчдийн 76% урьдчилан цаг захиалсан бөгөөд нийт үйлчлүүлэгчдийн 36.7% эмнэлэгт өөрийн биеэр ирж, дугаарлаж зогсож байгаад цаг авсан байна. Цаашид цахим бүртгэлийн ачааллыг бууруулахын тулд e-mongolia, 1800-0119, 77110111 утсаар эмчийн үзлэгийн цаг авах боломжтой талаар мэдээллийг иргэдэд илүү түгээх шаардлагатай байна. Мөн үйлчлүүлэгчдийн 7,8% УНТЭ-ийн 7711-0111 утсаар цаг авсан байгаад 77110111 цаг захиалгын утас ачаалал их учир хүрэлцээ хангалтгүй байгаа тул утасны операторын тоог нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна гэж дүгнэж байна.
- Амбулаторийн тусламж үйлчилгээний 53.9% 7 хоногийн дотор, 41.4% 7-30 хоног, 4,4% 1 сараас дээш хугацааны дараа үзлэгийн цаг товлөгдсөн байна. Үүнээс гадна үйлчлүүлэгчдийн 58% бодсоноос илүү хүлээх шаардлагатай байсан гэсэн дүгнэлт өгсөн. Эдгээрээс дүгнэхэд эмчийн үзлэгийн цагийн хүлээгдэл их байна гэж дүгнэж байна.
- Үйлчлүүлэгчдийн 62% товлосон цагтаа үзлэгтээ хамрагдаж чадахгүй байна. Үүний 9% хүлээж тэсэлгүй охиж явсан, 30% 1 цагаас дээш хугацаагаар хүлээсэн, 35% үзүүлэхийн тулд дор хаяж 30 минут эмчийн үүдэнд хүлээж байна. Амбулаторийн тусламж үйлчилгээ хүндрэл чирэгдэл ихтэй, шуурхай биш байна.
- Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн дунджаар 75% эмчийн гар халдваргүйтгэл болон өвчний оношилгоо, шинжилгээ, эмчилгээ болон эмийн гаж нөлөөний талаарх мэдээллийг өгсөн гэж дүгнэсэн.
- Амбулаторийн тусламж үйлчилгээний үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн ерөнхий дундаж 78,4% байна.


Харьцуулсан үзүүлэлт, шинжилгээ

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад амбулаторийн тусламж үйлчилгээний сэтгэл ханамжийн хувь 1,4% (2023 онд 76,6%)-аар өссөн байна.

Амбулаторийн ерөнхий сэтгэл ханамжийн харьцуулсан үзүүлэлт



Үйлчлүүлэгчийн эмнэлгийн үйлчилгээнд хэр сэтгэл хангалуун байгааг 2023 оны үзүүлэлттэй харьцуулахад



Амбулаторийн үйлчлүүлэгчдийн дунд авсан сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн дүгнэлт.

Нийт амбулаторийн үйлчлүүлсэн 226 үйлчлүүлэгчдийн саналаас ерөнхий сэтгэл ханамж 80.4% байна.

1. Эмнэлгийн үзлэгийн цаг олголтын тал дээр үзлэгийн цаг олголтын талаарх мэдээллийг иргэдэд сайн түгээх, E-mongolia эсвэл 1800-0119 цаг авсан тохиолдолд цахим бүртгэл дээр баталгаажуулах шаардлагатайг ойлгуулах, 7711-0111 операторын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.
2. Давтан үзлэг болон шинжилгээний цагийг оочир үүсгэлгүй, хүлээлтийг багасгах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.
3. Амбулаторийн тусламж үйлчилгээг авсан цагт нь оруулах, цагийг өрөө бүрийн үүдэнд дэлгэц дээр тод томоор тодорхой харуулж байх, үзлэгийн цагтаа үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.
4. Амбулаторийн ачааллын асуудал дээр эмч нарын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

5. Амбулаторийн тусламж үйлчилгээг үндсэн эмч ажиллаж байхаар хяналт тавьж ажиллах. Үндсэн эмч нар үзлэгийн хуваарьтай үед ажлын байран дээр байх. Тусламж үйлчилгээг үндсэн эмч, цагийн дагуу үзэх.
6. Үндсэн эмч, сувилагч, суралцагч эмч тус бүрийг ялгагдах нөхцөлийг бүрдүүлэх. Энгэрийн тэмдэг, мэсийн хувцас болон халаадаар ялгах.
7. Амбулаторийн үзлэгийн өрөөнүүдийн засвар тохижилтод анхаарах, Эхо-ний хэсгүүдэд дэвсгэр болон салфетка, ариутгагч бодисын хангамж болон хэрэглэлт дээр хяналт тавьж ажиллах, Лабораторийн шинжилгээ авах хэсгийн хаягжилт, зааврыг ойлгомжтой тодорхой болгох шаардлагатай байна.
8. Зохицуулах сувилагч, цахим бүртгэлийн ажилчдын харилцаа хандлагыг сайжруулах. 1 ажилтанд ноогдох ажлын ачааллыг тодорхойлон дүгнэж, шаардлагатай бол орон тоог нэмэгдүүлэх, ажлын ачааллын хуваарилалтыг зөв зохион байгуулах шаардлагатай байна.

ХАВСРАЛТ 3.

2024 ОНД АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2024.12.02

ЭМС-ын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/274 тушаалын дагуу, MNS 7014:2023 стандартад заагдсаны дагуу УНТЭ-ийн ЭМТҮЧАБА-аас гаргасан Амбулаторийн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны QR кодыг үүсгэн, 106 үйлчлүүлэгчээр авсан судалгааны тайлан.

Зорилго


Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Амбулаторийн үйлчлүүлэгчдээс шаардлагатай асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэн, зохих арга хэмжээг авч ажиллах

Зорилт

- Байгууллагын хөгжил, удирдлага зохион байгуулалтыг сайжруулахад нотолгоо болгон ашиглах

- Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг байгууллагын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд шаардлагатай нотолгоонд суурилсан мэдээллээр хангах


1.Та энэ удаа лавлагааны ажилтнаас туслалцаа авсан уу?



● Тийм
● Үгүй


Лавлагааны ажилтнаас туслалцаа авсан 79% байгаагаас дүгнэхэд Лавлагааны ажилтны туслалцаа хангалттай байна.

2.Та энэ удаад эмчид үзүүлэх цаг захиалсан уу?



● Тийм
● Үгүй


3.Та ямар байдлаар эмчид үзүүлэх цаг захиалсан бэ?



● 1800-0119 тусгай дугаарруу залгаж
● E-mongolia аппликейшнээр
● Өөрийн биеэр ирж, дугаарлаж зогсож байгаад
● Эмнэлгийн утасруу залгаж

Эмчид үзүүлэх/ шинжилгээ хийлгэх цаг хэрхэн авдаг үнэлгээгээр нийт үйлчлүүлэгчдийн 43,7% нь өөрийн биеэр ирж, 11,3% нь Эмнэлгийн утас руу залгаж, 31,3% нь e-mongolia application, 13,8% нь Нэгдсэн цаг захиалгаар /45,1% нь цахимаар/ цаг авч байна. Цаашид өөрийн биеэр ирж цаг авах, цахим бүртгэлд ачаалал үүсэхийг багасгахын тулд e-mongolia, 1800-0119, 77110111 утсаар эмчийн үзлэгийн цаг авах боломжтой талаар мэдээллийг иргэдэд илүү түгээх шаардлагатай байна. Мөн 77110111 цаг захиалгын утас ачаалал их учир хүрэлцээ хангалтгүй байгаа тул утасны операторын тоог нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна.

4. Танд хэр хугацааны дараа эмчид үзүүлэх цаг товлогдсон бэ? /Зөвхөн 1 хариулт сонгох/




5. Товлогдсон цаг нь таны үзүүлэхийг хүсэж байсан хугацаанаас хэр зөрүүтэй байсан бэ?




55% нь 7 ба түүнээс дээш хоногийн дараа үзлэгийн цаг олгогдож байгаа бөгөөд товлогдсон цаг нь таны үзүүлэхийг хүсэж байсан хугацаанаас 55% зөрүүтэй байсан гэсэн тул Амбулаторийн үзлэгийн оочрын асуудал дээр анхаарч, үйл ажиллагааг өөрчлөх шаардлагатай байна.

6. Та хүлээлгүйгээр товлогдсон цагтаа эмчид үзүүлж чадсан уу?




7. Эмчид үзүүлэх товлогдсон цаг өнгөрснөөс хойш хэр удаан хүлээсний эцэст Та эмчид үзүүлж чадсан бэ? /Зөвхөн 1 хариулт сонгох/




53,7% Эмчид үзүүлэх товлогдсон цаг өнгөрснөөс хойш 30 минутаас дээш хүлээсний эцэст үзлэгтээ хамрагдаж байгаа тул эмч нар үзлэгийн цагтаа тусламж үйлчилгээ үзүүлж иргэдийн хүлээлтийг бууруулж анхаарч ажиллах хэрэгтэй байна.

8. Өрөө бүрийн гадна хүрэлцэхүйц сандал байрласан байсан уу?




37,5% сандлийн хүрэлцээ байхгүй байна гэсэн тул хүлээлгийн сандлын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

9. Танд орох хаалга, давхар бүрийн үйлчлэх чиглэл, тусламж үйлчилгээний мэдээлэл ойлгомжтой байсан уу?




Хаалга, давхар бүрийн үйлчлэх чиглэл, тусламж үйлчилгээний мэдээллийг сайжруулах тал дээр анхаарах

10. Танд эмнэлгийн доторх кабинет бүрийн хаягжилт, үйлчилгээний мэдээлэл ойлгомжтой байна уу?




11. Үйлчлүүлэгчийн дараалал, хугацааг үйлчлүүлэгчид бүрэн харагдахуйцаар дэлгэцээр байршуулсан байсан уу?




Өрөөнүүдийн үүдэн дэх дэлгэцийн мэдээллийг тогтмол харагдаж байх тал дээр анхаарах


12. Өвчний онош, хийгдэх шинжилгээ болон эмчилгээний талаар эмч Танд ойлгомжтойгоор тайлбарлаж өгсөн үү?




13. Эмтэй холбоотой илэрч болох гаж нөлөөний талаар эмч танд анхааруулсан уу?




14. Эмч таныг анхааралтайгаар сонссон уу?




15. Та сувилагчтай харьцсан уу?



16. Сувилагч таныг анхааралтайгаар сонсож байна уу?




17. Танд үзүүлж буй тусламж, үзлэг, оношилгоо шинжилгээний өрөөний тохижилтыг хангалттай гэж үзэж байна уу?




Өрөөний тохижилтын байдалд 48,8% үйлчлүүлэгч хангалтгүй гэж дүгнэж байна.

18. Үйлчлүүлэгч та өөрийгөө эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтантай хүндэтгэлтэй харилцсан гэж бодож байна уу?



19. Энэ удаад та тус эмнэлгийн үйлчилгээнд хэр сэтгэл хангалуун байна вэ?



Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үзүүлэлт 85.9% байна.

20. Энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахад юунд анхаарах шаардлагатай байгаа талаарх саналаа энд бичнэ үү?

- Хүний нөөцөө нэмэгдүүлэх, эмчийн тоог нэмэгдүүлэх, ачааллыг багасгах
- Эмч, сувилагч нар харилцаан дээрээ анхаарах
- Захиалсан цагаа заавал цахим дээр баталгаажуулахыг болиулах
- Кабинетуудад мэргэжлийн үндсэн эмч нарыг суулгамаар байна
- Цагаар нь үзлэгт хамруулмаар байна.
- Эмч нар кабинетдаа цагтаа ирэх

Судалгааны үр дүн:

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий үзүүлэлт 85.9% байна.

- Эмнэлгийн үзлэгийн цаг олголтыг сайжруулах
- Амбулаторийн ачааллын асуудал дээр эмч нарын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн Амбулаторийн тусламж үйлчилгээг үндсэн эмч ажиллаж байхаар хяналт тавьж ажиллах.
- Амбулаторийн үзлэгийн өрөөнүүдийн засвар тохижилтод анхаарах, Эхо-ний хэсгүүдэд дэвсгэр болон салфетка, ариутгагч бодисын хангамж болон хэрэглэл дээр хяналт тавьж ажиллах, Лабораторийн шинжилгээ авах хэсгийн хаягжилт, зааврыг ойлгомжтой тодорхой болгох шаардлагатай байна.
- Зохицуулах сувилагч, цахим бүртгэлийн ажилчдын харилцаа хандлагыг сайжруулах

- Амбулаторийн тусламж үйлчилгээг авсан цагт нь оруулах, цагийг өрөө бүрийн үүдэнд дэлгэцээр тод томоор тодорхой харуулж байх, үзлэгийн цагтаа үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ 4.

ЭМНЭЛЭГТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДЭЭС ЭМЧИЛГЭЭНИЙ ХООЛНЫ ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Уг сэтгэл ханамжийн судалгааг УНТЭ-ийн хэвтэн эмчлүүлэгчдээс эмчилгээний хоолны сэтгэл ханамжийн судалгааг иж бүрдэл хоолоор үйлчилж буй Урологи-Андрологийн төв, Чих хамар хоолой судлал, мэс заслын тасагт, Зүрхний төв болон бусад төв, тасгуудад хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдийг хамруулж нийт 214 хүнээс цаасан хэлбэрээр авч

судалгааны үр дүнг боловсруулав. Судалгаа нийт 5 үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд үр дүнг доор харуулав.

Зорилго: Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээний хоолны чанар, үйлчилгээг судлан, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах, иж бүрдэл эмчилгээний хоолоор үйлчлэх асуудлыг шийдвэрлэн, зохих арга хэмжээг авч ажиллах

Зорилт:

- Эмчилгээний хоолны үйлчилгээг сайжруулахад нотолгоо болгон ашиглах
- Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг байгууллагын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд шаардлагатай нотолгоонд суурилсан мэдээллээр хангах


1. Эмчилгээний хоолны хэм, температур




2. Эмчилгээний хоолны амт, чанар, шим тэжээллэг байдал




3. Эмчилгээний хоолны ариун цэвэр, эрүүл ахуйн байдал



4. Эмчилгээний хоолны түгээлт




5. Гаднаас хоолны эргэлт авсан эсэх



Дүгнэлт

1. Хэвтэн эмчлүүлэгчдийн гаднаас хоолны эргэлт авах байдал иж бүрдэл хоолоор үйлчилж буй тасаг (УАТ, ЗТ, ЧХХМЗТ)-ууд бусад төв, тасагуудтай харьцуулахад 49-33% болж хоолны эргэлт авах байдал буурсан
2. Эмчилгээний хоолны амт, чанар, шим тэжээллэг байдлыг 1-5 оноогоор үнэлэхэд иж бүрдэл хоолоор үйлчилж буй тасгуудыг бусад тасагуудтай харьцуулахад 3.5 - 4.3 оноо болж нэмэгдсэн
3. Эмчилгээний хоолны хэм, температур халуун гэж дүгнэсэн өвчтөнүүдийн хувь иж бүрдэл болон бусад тасгуудад 25-57% болж нэмэгдсэн
4. Иж бүрдэл хоолоор үйлчилж буй тасгуудад эмчилгээний хоолны ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг маш сайн гэж дүгнэсэн үйлчлүүлэгч 20-42 % болж нэмэгдсэн
5. Судалгааны үр дүнд иж бүрдэл хоолоор үйлчилж буй тасгуудад эмчилгээний хоолны амт, чанар, шим тэжээллэг байдал, хоолны хэм, гаднаас эргэлт авах байдал, ариун цэвэр, эрүүл ахуйн байдал илт сайжирсан нь үр дүн харагдсан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Боловсруулсан: Чанарын мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн  С.Гэрэлчимэг

Хянасан: ЭМТҮЧАБА-ны дарга  М.Одсүрэн



2024 ОНЫ АЖИЛТАНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУДААС АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

(2024.06.15-2024.12.31)

1. Зорилго

Энэхүү судалгаа нь манай байгууллагын ажлын орчин нөхцөл, ажилчдад үзүүлж буй нийгмийн баталгаа, сургалт дэмжлэг, хамт олон хоорондын харилцаа хандлага, удирдлагын үйл ажиллагаанд сэтгэл ханамж хэр байгаа талаар тодорхойлж, үнэлэлт дүгнэлт хийж, үнэ цэнтэй авьяас чадвартай боловсон хүчнээ хадгалах, байгууллагын нэр хүндийг өсгөн, ажилчдыг оюун санаа болон бие махбодын хувьд эрүүл байлгах зорилготой юм.

2. Зорилт

- Ажилчдын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх
- Хүний нөөцийн бодлого, түүний хэрэгжилт, ажиллагсад хоорондын харилцаа ба уур амьсгалыг тодорхойлох
- Ажиллагсад ба удирдлага хоорондын харилцаа, тэдний үр дүнтэй хамтын үйл ажиллагааг хэрхэн нэмэгдүүлэх
- Хун тус бүрийн зан чанар, онцлог дээр тулгуурлан хувь хүний сэтгэл ханамжийн байдлыг тодорхойлох
- Удирдлагын үйл ажиллагаа эсвэл байгууллагын ерөнхий соёлд учирч болзошгүй бэрхшээлийг эрт илрүүлэх
- Судалгааны үр дүнгээр ажилчдын сэтгэл ханамжийг бууруулж буй шалтгаануудыг тодорхойлохоор зорилттой.

3. Онолын үндэслэл


Ажлын байрны сэтгэл ханамж нь олон хэмжээст бөгөөд ажилчид болон байгууллагад аль алинд нь чухал нөлөөтэй хүчин зүйл болохыг олон судалгаанд тусган харуулсан байдаг. Тухайлбал, ажлын байран дахь сэтгэл ханамж нь ажилчдын бүтээмж, гүйцэтгэл, чанар, ажлын идэвхи, ажлын байрны тогтвортой байдал бие болон сэтгэцийн эрүүл мэнд, амьдралын ерөнхий сэтгэл ханамжид нөлөөлөх чухал хүчин зүйлийн нэг болдог байна. Сэтгэл ханамж, ажлын хүчин чармайлтыг судлахад **хэрэгцээний онол**, байгууллагын зан байдлыг урьдчилан таамаглахад **хүлээлтийн онол**, ажилчдын хэрэгцээ, хичээл зүтгэлийг судлахад **тэнцвэрийн онолыг** түлхүү ашигладаг. Байгууллагын бодлоготой холбоотой хүчин зүйл нь шагнал урамшуулал, удирдлага-хяналт, шийдвэр гаргах, туршлага зэргийг агуулна. Ажлын онцлог шинж чанартай холбоотой хүчин зүйл нь ажлын ачаалал, ажиллах орчин зэргийг агуулна. Тодорхойлогч хүчин зүйлсийг мөн гадаад хүчин зүйл, хувь хүний хүчин зүйл гэж ерөнхийд нь хоёр

ангилсан байдаг. Гадаад хүчин зүйлд цалин, үр өгөөж, тусламж дэмжлэг, ажлын нөхцөл байдал, заах, ур чадвар мэдлэг, хүчин зүтгэлд тохирсон шагнал урамшуулал зэргийг багтаасан байдаг.

4. Судалгааны арга зүй

Судалгааны арга зүй хэсэг нь судалгааны түүврийн мэдээлэл, өгөгдөл цуглуулах, боловсруулах арга зүй хэсгээс бүрдэнэ.

- Судалгаанд оролцогчдыг бүлэглэх замаар хуваав.
- Импульсийн судалгааны арга болон хувь хүний 360 градусын судалгааны аргуудыг түлхүү ашиглав
- Судалгаанд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн нийт ажилчдыг хамруулан, цахим хэлбэрээр, нэрээ нууцалсан төлөвтэйгөөр, хоёр хоногт судалгааг авав.
- Судалгаанд 270 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон бусад төрлийн ажилчид хамрагдсан байна.
- Нийт 5 бүлэг бүхий 24 асуулт судалгаагаар ажилчдын сэтгэл ханамжийг үнэлсэн болно.




5. Судалгааны үр дүн

Энэхүү судалгаанд хашиж буй албан тушаал, нас болон нийт байгууллагад ажилласан хугацааг нь тодорхойлж, сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийг 5 бүлэгт хуваасан 24 асуултаар судлав.

5.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИД

Нийт 270 ажилтнууд оролцсоноос 104 нь Хүний их эмч, 79 нь Сувилагч, 25 нь Эмнэлгийн тусгай мэргэжилтэн, 25 нь Эмнэлгийн дэмжих ажилчид, 8 нь Эмнэлгийн үйлчлэгч мөн 35 нь бусад мэргэжлийн хүмүүс хамрагдсан байна.



Судалгаанд оролцогчдын 7,7% нь (18-25 нас), 37,3% нь (26-35 нас), 30,3% нь (36-45 нас), 21,8% нь (46-55), 3% нь (55 ба түүнээс дээш) насныхан байна.



Судалгаанд оролцогчдын идэвхи 1-5 жил ажилласан ажилчдын дунд 26,6% хамгийн өндөр байсан бол 1 хүртэлх жил ажиллаж буй хүмүүс дунд 8,5% хамгийн бага байна.

5.2 АЖЛЫН БАЙРНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН




Ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааны ерөнхий дүгнэлт: Дээрх 4 графикуудаас харахад ажлын орчин нөхцөл, тохижилт болон байгууллагын хангамж, цалин урамшууллаас хамааралтай сэтгэл ханамжийн судалгаанд **23,9 %** нь сэтгэл хангалуун, **44,6 %** нь дунд зэрэг гэж хариулсан бол **28,9 %** нь сэтгэл хангалуун бус байдаг гэх дүгнэлт гарсан байна.


5.3 ХООРОНДЫН ХАРИЛЦАА СЭТГЭЛ ХАНАМЖИЙН БАЙДАЛ




Таны ажлын хамт олон таны хийж буй ажлыг ойлгож үнэлж чаддаг гэж үзэж байна уу?



Таны нрээдүй хэтийн зорилго манай байгууллагын зорилготой нийцэж байна гэж үзэж байна уу ?




Та өөрийн ажиллаж буй байгууллага, ажил мэргэжлээрээ бахархдаг уу?



Ажилтнуудын хоорондын харилцаа сэтгэл ханамжийн байдал судалгааны ерөнхий дүгнэлт: Дээрх 5 графикуудаас харахад хамт олон хоорондын харилцаа, нээлттэй байдал болон ажлын зорилго, ажил мэргэжлээрээ бахархах сэтгэл ханамжийн судалгаанд **38.18 %** нь сэтгэл хангалуун, **42,18 %** нь дунд зэрэг гэж хариулсан бол **20,6 %** нь сэтгэл хангалуун бус байдаг гэх дүгнэлт гарсан байна.

5.4 АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН ХАНГАМЖ


Манай байгууллагын нийгмийн хангамж болон нийгмийн баталгаанд сэтгэл хангалуун байдаг?






Ажилтнуудын нийгмийн хангамжийн судалгааны ерөнхий дүгнэлт: Дээрх 3 графикаас харахад ажилчдын нийгмийн хангамж, нийгмийн баталгаа, ажил-амралтын зохицуулга болон хоол хүнс, амт чанарын үр дүнг авч үзвэл: **13,7 %** нь сэтгэл хангалуун, **44,1 %** нь дунд зэрэг бол **44,7 %** нь сэтгэл хангалуун бус байдаг нь харагдаж байна.

5.5 ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ



Хүний нөөцийн хөгжлийн судалгааны ерөнхий дүгнэлт: Байгууллагын захиргаа, хүний нөөцийн бодлого хэрэгжилт, мэдээ мэдээллийн хүртээмжийн талаарх сэтгэл ханамжийн судалгаанд **32.1 %** нь сэтгэл хангалуун, **48,3 %** нь дунд зэрэг, **21,6 %** нь сэтгэл хангалуун бус байна.

5.6 ХУВЬ ХҮНД ТУЛГУУРЛАСАН АСУУЛТУУД



Хувь хүнд тулгуурласан асуултууд судалгааны ерөнхий дүгнэлт: Хүн тус бүрийн зан чанар, онцлог дээр тулгуурлан хувь хүний сэтгэл ханамжийн үр дүнг харахад 82,55% нь бусадтай хамтарч ажиллах, ажлын үр дүн болон ажлын орчинд үүсэх зөрчилдөөнийг асуудалгүй шийдвэрлэдгийг харж болж байна.

6. Дүгнэлт, хэлэлцүүлэг

2024 оны жилийн эцсийн ажилтнуудаас авсан 5 бүлэг бүхий 24 асуулттай ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаанд эмч, сувилагч нар 68 %-тай хамгийн идэвхтэй оролцсон ба үүнээс 26-45 насныхан 37,1 %-тай байна.

Судалгаанд оролцсон 270 ажилтнуудын 23,9 % нь ажлын орчин нөхцөл, тохижилт болон байгууллагын хангамж, цалин урамшуулалд сэтгэл хангалуун, харин хамт олон хоорондын харилцаа, нээлттэй байдал болон ажлын зорилго, ажил мэргэжлээрээ бахархах сэтгэл ханамжийн судалгаанд 38.18 % нь сэтгэл хангалуун гарсан байна.

Байгууллагаас ажилтнуудад үзүүлж буй нийгмийн хангамж, баталгаа болон тэдний ажил амралтын зохицуулгын үр дүн 13,7 % нь сэтгэл хангалуун байгаа бол байгууллагын

захиргаа, хүний нөөцийн бодлого хэрэгжилт, мэдээ мэдээллийн хүртээмжийн талаарх сэтгэл ханамжийн судалгаанд 32,1 % сэтгэл хангалуун байдаг гэсэн үр дүн гарсан.

Мөн хүн тус бүрийн зан чанар, онцлог дээр тулгуурлан хувь хүний сэтгэл ханамжийн үр дүнг харахад 82,55 % нь бусадтай хамтарч ажиллах, ажлын үр дүн болон ажлын орчинд үүсэх зөрчилдөөнийг асуудалгүй шийдвэрлэдгийг харж болж байна.




Үүнээс ажилчид **ажлын орчин нөхцөл ба байгууллагын хангамж, цалин урамшуулал мөн ажилчдын нийгмийн баталгаанд** хамгийн сэтгэл ханамжгүй байдаг гэсэн үр дүн гарчээ.

Ажилчдаас авсан нэн тэргүүний тулгамдаж буй асуултаас үүнийг үндэслэвэл:

- Цалин урамшууллыг нэмэгдүүлэх
- Ажлын орчин нөхцөл, хангамжийг сайжруулах
- Ажилд ашиглагдах техник төхөөрөмжийн хүрэлцээг нэмэгдүүлэх
- Байгууллагын дотоод болон гадаад орчны тохижилт, зогсоол зэргийг сайжруулах
- Ажилчдын нийгмийн баталгаа, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг ажилд багтана.

Таны хувьд манай байгууллагын яаралтай шийдвэрлэх нэн тэргүүний асуудал юу вэ?



Ажилтнуудаас ирүүлсэн санал:

- 1.Сувилагч нарын ажлын ачааллыг зөв үр дүнтэй хэмжих, ажлын гүйцэтгэлийн үнэлгээг яаралтай шийдвэрлэх
2. Цалин хөлсний урамшууллыг үнэн бодитой байлгахад анхаарах, бусад шатлал ижил эмнэлгүүдийн нэг адилаар цалингийн жишиг тогтоох
3. Магистр, докторын зэргийн цалингийн нэмэгдлийг өөрчлөлтийг тусгах
4. Ажилчдын үд дүнг зөв дүгнэх, үр дүн дүгнэх алба 10 оноогоо норм журмын дагуу дүгнэж өгөх, Нийтээр нь 10 оноог нь өгдөггүй энэ хууль бус үйлдлээ зогсоох.
5. Хоолны газрын хоол амт чанарт анхаарах
6. Удирдлагын хүмүүсийн харилцаа хандлагыг сайжруулах сургалтад өөрсдийг нь хамруулах.
7. Зарим эмч нар үнэхээр ёс зүйгүй харьцаатай байна.
8. Ажлын хувцас хангалтгүй. Угаах газаргүй орон гэртээ аваачиж угаадаг.
9. Ажлын бус цагаар ажлын үүрэг даалгавар өгөхгүй байх, амралтын хугацаанд залгахгүй байх
- 10.Эмчлүүлэгчийн хажууд загнаж буруу ойлгуулж байна

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Боловсруулсан: ХНХА-ны хүний нөөцийн менежер

Хянасан: Захиргаа, хүний нөөцийн албаны дарга

Э.Энхбилэг

19.Мөнхтуул



1925

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

2024 ОНЫ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ
ҮНЭЛГЭЭНИЙ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

2024 оны Сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээний дагуу УНТЭ-ийн Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлж ажилласан.

Нэг. Эрүүл мэндийн ажилтанд тавигдах шаардлагын хүрээнд

1.1. ЭМС-ын 2023 оны А/274 тоот тушаал Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг ханган эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах

Стандартыг нийт ажилтнуудад таниулах, мэдээлэх зорилгоор ЭМТҮЧАБА-аас нийт эмч нарын яриа, сувилахуйн нэгдсэн яриа, ахлах сувилагч нарын яриа, амбулатори, цахим бүртгэл, эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн албаны 550 гаруй ажилтнуудад сургалт зохион байгуулсан.



1.2. Сувилагч, тусгай мэргэжилтнүүд, ажилтануудын харилцаа хандлагад хяналтын хуудсаар үнэлгээ хийх, үнэлгээний дүнд суурилсан сургалт арга хэмжээг зохион байгуулах

УНТЭ-ийн Сувилахуйн албанаас ЭМС-ын А/186, А/319, А/537, А/505 тушаал, УНТЭ-ийн захирлын А/135 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор нийт 7 чиглэл 50 үзүүлэлт бүхий хяналтын хуудсыг боловсруулан сувилагч, тусгай мэргэжилтний үйл ажиллагаанд хяналт тавьж байна.

- 1) Ажлын цаг ашиглалт /1-6/
- 2) Хувцаслалтын хэм хэмжээ /7-14/
- 3) Биеэ авч явах соёл /15-21/
- 4) Ээлж хүлээлцэлтийн үйл явц /22-32/
- 5) Гар угаах, халдваргүйжүүлэлт /33-36/
- 6) Хог хаягдлыг ангилан цуглуулах /37-46/
- 7) Тусгаарлан сэргийлэлт /47-50/


Тус хяналтын хуудсаар мэс заслын тасгийн сувилахуйн багийн ээлж хүлээлцэлтэд нийт 81 удаагийн тойролт, дотрын сувилахуйн багийн ээлж хүлээлцэлтэд 72 гаруй удаагийн тойролт хяналт хийж, сувилагч тусгай мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгч байна.

Үүнээс ажлын цаг ашиглалт, хувцаслалтын хэм хэмжээ, биеэ авч явах соёлын хэм, хэмжээ гэсэн үзүүлэлт хяналтын хуудсаар хийсэн үнэлгээгээр 94.2% байна.

Хоёр. Үйлчлүүлэгчийн харилцааны ерөнхий шаардлагын хүрээнд

2.1. Эмнэлгийн гадаад цахим хуудас болон амбулаторийн хэсэгт үйлчлүүлэгчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг танилцуулах мэдээллийг байршуулах

Эмнэлгийн гадаад цахим хуудаст ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ цэсний Амбулатори дэд цэсэнд үйлчлүүлэгчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлагын мэдээллийг байршуулсан.



2.2. Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчтэй харилцах эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх

Эрүүл мэндийн байгууллагуудад дохионы хэлмэрчийг ажиллуулах, сонсголгүй, хэл ярианын бэрхшээлтэй иргэдийг чирэгдэлгүй эмнэлгийн тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор амбулаторийн хэсэгт дохионы хэлний сургалтанд хамруулсан сувилагч, цахим бүртгэгч нийт 4 ажилтныг мэдлэг сэргээх сургалтад хамруулан ажиллуулж байна.



Мөн хэвтүүлэн эмчлэх төв, тасгуудаас ЧХХМЗТ, МХНТ-ууд тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчтэй харилцах сувилагч бэлтгэн, анхан шатны сургалтанд хамруулан ажиллуулж байна.

2.3. Зонхилон тохиолдох өвчний талаарх эрүүл мэндийн сөрөг, ташаа ойлголт, мэдээллийн талаар эрүүл мэндийн боловсрол олгох контентийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран бэлтгэх, нийтэд түгээх

УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн алба нь 2024 онд хүн амд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох контент бэлтгэн, сурталчлах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан.

1. ARSLAN.MN сайт нь нийгмийн хариуцлагын хүрээнд УНТЭ-ийн ЗАА, НЭМА-дуудтай хамтран ажиллаж 2024 оны туршид ард иргэдийн эрүүл мэндийн боловсролд зориулсан “Сувилагчийн зөвлөгөө” 5 видео контентийг бэлтгэж эмнэлгийн гадаад цахим хуудас болон фейсбүүк цахим хуудсанд байршуулж нийтийн хүртээл болгосон.



2. УНТЭ-ийн Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасгийн хөдөлгөөн засалч Г.Туул 2024.05.15-ны өдөр Монгол HD телевизын "Өнөө өглөө" хөтөлбөрт "Тархины цус харвалтын дараах хөдөлгөөн заслын эмчилгээний ач холбогдол" сэдвээр зөвлөгөө мэдээлэл өгч харвалтын дараах байдалтай иргэдэд зориулсан хөдөлгөөн засах дасгал хөдөлгөөн зааж өгсөн.
3. УНТЭ-ийн НЭМА-ны хоолзүйч Э.Санчир нь 2024.02.19-ны өдөр Mongol HD телевизд Terminal 1.0, 2024.05.15-ны өдөр Mongol HD телевизийн Нүүдэл-Шийдэл нэвтрүүлэгт тус тус оролцож хүн амын дундах хооллолт, өвөрмөц бүлгийн хоол шим тэжээлийн талаар зөвлөгөө мэдээллийг өгсөн.



Зураг. Ярилцлагын явцаас


4. ЭМЯ-наас хэрэгжүүлсэн "Ирээдүйгээ бүү сор" тамхидалтыг бууруулах нөлөөллийн аянд УНТЭ нь үндсэн чиг үүргийн дагуу оролцож Уушги, харшил судлалын төвийн эмч нар "Электрон тамхины хор хөнөөл" сэдвээр зөвлөгөө мэдээлэл бүхий өсвөр үеийхэнд зориулсан контент бэлтгэж сошиал орчинд түгээсэн бөгөөд НЭМА-аас мэргэжлийн байгууллагын зорилтот бүлгийн хүн амд зориулан бэлтгэсэн ухуулга сурталчилгааны материал, мэдээ, мэдээллийг Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн албан ёсны мэдээллийн сувгууд болох цахим фэйсбүүк пэйж хуудас, хамт олны групп, гадаад дотоод цахим хуудсандаа байршуулж нийтэд түгээсэн.

Гурав. Эрүүл мэндийн байгууллагын хаягжилтыг хийх хүрээнд

- 3.1. Үзлэг болон оношилгоо, шинжилгээний өрөөний үүдэнд тухайн тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, сувилагч, үйлчилгээний төрлийн талаарх мэдээллийг байршуулна.

УНТЭ-ийн Амбулаторийн тасаг нь үйлчлүүлэгчийн үзлэгийн цаг, үзүүлэх дарааллыг All in One ухаалаг компьютер, дэлгэцийг ашиглан хүргэдэг бөгөөд 2024 оны III дугаар улирлаас эхлэн тус үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, үйлчлүүлэгч нарыг тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч нарын танилцуулга мэдээллээр хангах зорилгоор Мэдээлэл технологийн албанаас eHealth програмд

нэмэлт хөгжүүлэлт хийн, үзлэг оношилгоо хийж буй эмч нарын мэдээллийг амбулаторийн бүх кабинетийн үүдэнд суурилуулсан дэлгэц дээр гаргадаг болсон. Мөн ард иргэдэд нэн чухал цаг үеийн мэдээ, мэдээллийг видео хэлбэрээр байршуулах хөгжүүлэлтийг хийж байна. Жнь: Маскаа зүү, гараа угаа, эмийг зөвхөн жороор хэрэглэе гэх мэт.



Зураг. Дэлгэцэнд гарч буй мэдээлэл

3.2. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд хэвтэн эмчлүүлэгчийн журам, эргэлтийн хоол, гар утасны хэрэглээ болон ар гэрт зөвлөгөө мэдээлэл өгөх зорилго бүхий AR цахим хөтөч ажиллуулах, мэдээллийн сан үүсгэх

УНТЭ-ийн Мэдээлэл технологийн алба нь хиймэл оюунд суурилсан хөтчийн тусламжтайгаар эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох болгон тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэх зорилгоор Эй Ар Монголиа ХХК-тай нийгмийн хариуцлагын хүрээнд буюу үнэ төлбөргүй хийх гэрээг 2024 оны 3 сард хийсэн.

Гэрээний дагуу 3 үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байна.

Энэ нь бодит ертөнцийг хиймэл оюун ухааны тооцоолол болон ялган таних алгоритм дээр үндэслэн цахим контенттой холбох дэвшилтэт технологи юм. Ухаалаг утсаараа QR зураг бүхий наалтыг уншуулахад дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой хялбар үйлчилгээ юм. Үүнд: Тухайн зургийг уншуулсан тохиолдолд дэд бүлэгт хуваагдсан олон талын мэдээлэл авах боломжтой.

- 1) Урологи андрологийн мэс заслын үеийн талаарх эмчийн зөвлөгөө, мэдээлэл нийт 4 дэд бүлэгтэй мэдээлэл багтсан.



- 2) Дурангийн оношилгоо хийлгэх үйлчлүүлэгчийн анхаарах зүйлсийн талаарх зөвлөгөө нийт 3 дэд бүлэгтэй мэдээлэл багтсан.




- 3) Хэвтэн эмчлүүлэгчийн өрөөнд хэвтэн эмчлүүлэх үеийн журам санамжуудыг танилцуулах 3D хөтөч гарч ирж танилцуулна. Нийт 7 дэд бүлэгтэй мэдээлэл багтсан.



Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын гадаад орчинд тавих ерөнхий шаардлагын хүрээнд

4.1. Тусгай хэрэгцээтэй, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд зориулсан MNS 6055, Иргэний барилга төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага” стандартыг хангасан шат, шатны бариул, налуу замыг сайжруулах, сул хараатай иргэд эрүүл мэндийн байгууллагаар саадгүй үйлчлүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллана.

УНТЭ-ийн амбулаторийн хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээ, оношлогоо, эмчилгээ үзүүлэхдээ биеийн байдал хүнд, өөртөө үйлчлэх боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийг эрэмблэн ангилалт хийж, тэргэнцэрээр үйлчилж, шуурхай байдлыг хангаж ажиллаж байна. Амбулаториор үйлчлүүлж буй цус харвалтын дараах саа саажилтай, өндөр настай явж чадахгүй, мэс заслын дараах байдалтай үйлчлүүлэгчдэд тэргэнцэрээр үйлчилгээ үзүүлдэг. Харуулын албатай хамтран эвдэрсэн 10 тэргэнцрийг засч сэлбэж аюулгүй байдлыг ханган үйлчилгээнд гаргасан болно. Шинээр 4 тэргэнцрийн хангалтыг хийлгэж чек листээр бүрэн бүтэн шалган аюулгүй байдлыг бүрдүүлэн үйлчилж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 2176 үйлчлүүлэгчдэд хөнгөн шуурхай очер дугаар харгалзахгүй эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж тэдгээрийн орчин бүрдүүлэлт тохижилтыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж ажилласан. Амбулаторийн үйлчилгээ хариуцсан ажилтнууд нь өдөр бүр тэргэнцэрийн бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааг ханган хяналтын хуудсаар хяналт тавьж үйлчилгээнд гарган ажилладаг.



Зураг. Тэргэнцэр болон шатны бариул

Мөн зохицуулах сувилагч нар нь хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийн артерын даралт үзэж, лавлагаа мэдээллийн ажилтан хөдөлгөөний

урсгалыг чиглүүлж 3725 удаа тэргэнцрээр үйлчилж шаардлагатай оношлогоо, шинжилгээний хэсэг, кабинетүүдэд хүргэн өгч тэргэнцрийн үйлчилгээг чек лист үнэлэн хөтлөж аюулгүй ажиллагааг ханган ажилласан.

4.2. Эмнэлгийн ногоон байгууламжийн арчилгаа UCS0803B:2022 ногоон байгууламжийн арчилгаанд тавих шаардлагыг хангаж ажиллана

УНТЭ-ийн Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн албаны ажилтнууд эмнэлгийн гадна хэсгийн ногоон байгууламжийг хариуцан ажилладаг бөгөөд ногоон байгууламжын арчилгааны сургалтыг Люксландшафт ХХК-с 2 удаа авсан. Гадна талбайн ажилчдын багаж хэрэгслийг шинэчилсэн.



4.3. Эмнэлгийн гадна талбайн тохижилтыг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

2024 оны 05 дугаар сарын 8-ны өдөр Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн албанаас Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан, Люксландшафт ХХК, Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй гурвалсан гэрээ байгуулан эмнэлгийн гадна талбайн тохижилтын ажлыг хийсэн.

Уг ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

Нэр	Тоо хэмжээ
Зүлэгжүүлэлт	925м2
Бүйлс	20ш
Голтбор	25ш

Агч	4ш
Үхрийн нүд	6ш
Тэхийн шээг	10ш
Хус	3ш
Гацуур	10ш
Өрөл	8ш
Монос	4ш

Тав. Эрүүл мэндийн байгууллагын дотоод орчинд тавих ерөнхий шаардлагын хүрээнд

5.1. Үйлчлүүлэгчдийн төрөл хэрэгцээг тодорхойлж, дэмжлэгт орчин бүрдүүлж ажиллах

Амбулаторийн хэсгээр үйлчлүүлэж буй зарим үйлчлүүлэгчийн төрөл хэрэгцээг тодорхойлж, кабинетын зохицуулах сувилагч, цахим бүртгэлийн ажилтнуудад мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулсан.

ХАРИЛЦАА ХАНДЛАГЫН СЭДЭВТ СУРГАЛТ 3 УДАА ЗОХИОН БАЙГУУЛСАН НЬ



Харилцааны эрүүл уур амьсгал бие биегд нь өөрсө сэтгэгдэхийг хандлага тухайн зохиогддог уурыг заавал шууд мөнгөөс нь

Яаруу тэвчээртэй үйлчлүүлэгчидтэй хэрхэн харилцах

Зураг. Яаруу, тэвчээргүй үйлчлүүлэгчидтэй хэрхэн харилцах талаар сургалт орж буй нь

Амбулаторийн хэсэгт үйлчлүүлэгч нарт зориулсан дэмжлэгт орчин бүрдүүлэхээр хандивлагч байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд төсвийн тодорхой хувийг шийдвэрлэн засварын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хийж байна. Мөн 2024 оны эхний 11 сарын байдлаар 1-4 давхарт байрлах кабинетүүдийн 68 цонхны хөшгийг сольж, 120 цэгт гэрэлтүүлгийг сайжруулсан.

2025 оны 1-р улиралд багтан 55 ширхэг модон цонхыг вакум цонхоор солих, 1-4 давхарт ХБИ-тэй иргэдийн эрэгтэй, эмэгтэй 00 өрөөг стандартын дагуу засварлахаар шийдвэрлэсэн.

5.2. Эмнэлгийн гадаад цахим хуудсан алба, төв, тасаг нэгжийн танилцуулгыг байршуулах

УНТЭ-ийн гадаад цахим хуудасны танилцуулга хэсгийн – АЛБА, ТӨВ, ТАСГИЙН ТАНИЛЦУУЛГА - буланд алба, төвүүд, эмчилгээний тасгууд, дэмжих үйлчилгээний албадуудын танилцуулга, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны танилцуулгыг байршуулсан. Шинэчлэл 100%-тай байна. Бүх төв, тасаг, нэгжийн зураг авалт хийгдсэн.



5.3. Эмнэлгийн гадаадад цахим хуудсанд үйлчилгээний төрөл, үйлчлүүлэх дараалал, хугацааг байршуулах

Эмнэлгийн гадаад цахим хуудасны ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ цэсний АМБУЛАТОРИ дэд цэсэнд үйлчилгээний төрөл, үйлчлүүлэх дарааллыг байршуулсан.



5.4. Эмнэлгийн гадаад цахим хуудсанд алба, төв, тасаг нэгжийн байршлын зургийг мэдээлэх

Эмнэлгийн гадаад цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдал хэсэгт эмнэлгийн алба, төв, тасаг нэгжийн байршлын зураг байршуулсан.



5.5. Эмнэлгийн амбулаторын хэсгийн ариун цэврийн 1 өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх бүрэн тоноглогдсон ариун цэврийн өрөө болгон засаж тохижуулна.

УНТЭ-ийн Амбулаториор үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд зориулсан, нөхцөл бүрдүүлсэн ариун цэврийн өрөөг 2-4 давхар тус бүрт гарын доорхи материал ашиглан тохижуулсан.



5.6. Эмнэлгийн тасаг нэгж, төв, нийтийн хэсгийн эвдэрсэн ариун цэврийн өрөөний тоноглолыг шинэчлэх

Эмнэлгийн нийт тасаг төвүүдийн ариун цэврийн өрөөний тоноглолыг эвдэрсэн тухай бүрд сольж шинэчилж байна. Эмнэлгийн хэмжээнд нийт амбулатори болон хэвтэн эмчлүүлэх 2 хэсгийг хамарсан 152 ариун цэврийн өрөө ашиглаж байгаагаас ашиглалт 100%-тай байна.

5.7. Эмнэлгийн нийтийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээний тоноглол сайжруулах

УНТЭ-ийн Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн албанд 1 ширхэг автомат шал цэвэрлэх машин хандиваар ирсэн бөгөөд нийтийн талбайн цэвэрлэгээ хийх ажлыг хөнгөвчилж өгсөн.

Зургаа. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хүрээнд

6.1. ТАЗ-ийн “Ёс-той Зүй-тэй” ёс суртахуун, ёс зүйн нөлөөллийн нэг сарын аян зохион байгуулсан.

2024.11.01-2024.11.29-ний хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хорооноос 2024 оны 11 дүгээр сарыг “Ёс-той Зүй-тэй” ёс суртахуун, ёс зүйн нөлөөллийн сар болгон зарлаж байна. Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь “Ёс-той Зүй-тэй” ёс суртахуун, ёс зүйн нөлөөллийн нэг сарын аянд “Улсын Нэгдүгээр төв Эмнэлэг”-ийн хамт олон нэгдэж хамтарч ажилласан.

- ✓ Аяны хүрээнд зохион байгуулагдсан 4 удаагийн цахим сургалтад УНТЭ-ийн ажилтнуудыг хамруулсан. (сургалтын тайлан хэсэгт дэлгэрэнгүй)
- ✓ Аяны хүрээнд авсан “Төрийн албан дахь ёсзүйн зөрчил, шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс” сэдэвт асуумж судалгаанд ЁЗСХ оролцсон.



Зураг. Аяны уриа зураг

6.2. Ажилтнуудын ёсзүй, харилцаа, хандлага, хөдөлмөрийн сахилга батыг сайжруулах чиглэлд хийсэн ажлууд, сургалт зохион байгуулсан.

1. Ёсзүйн салбар хороо нь 2024 оны эхний 10 сард эмнэлгийн Захиргаа болон албан байгууллагуудтай хамтран 18 удаагийн сургалтыг зохион байгуулж,

давхардсан тоогоор 1650 эмч, 1694 эмнэлгийн мэргэжилтэн, 553 дэмжих үйлчилгээний ажилтан хамрагдсан байна.

УНТЭ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэх чиглэлд хамтран нэгжүүдтэй хамтран ажиллаж байна. Уг стандартыг эмнэлгийн удирдлага, төв, тасаг нэгжийн эрхлэгч нарт таниулах, хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2024.01.17-ны өдөр АШУҮИС-ийн Харилцааны тэнхимийн багш С.Наранчимэгтэй хамтарч сургалтыг амжилттай зохион байгуулсан.



Зураг. Сургалтын явц

2. УНТЭ нь "Эрх зүйн боловсрол ба Эрүүл мэнд" ТББ-ын захирал, АУ-ны доктор, дэд профессор, Хуульзүйн ухааны магистр М.Цэрэнбаттай хамтран 2024.01.18-ны пүрэв гаригийн өглөө 08.00-10.00 цагт "Төрийн албан хаагчийн ёсзүй болон эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хэм хэмжээ" сэдэвт сургалтыг УНТЭ-ийн төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн I, II дамжааны суралцагч резидент эмч нарт амжилттай зохион байгууллаа.



Зураг. Сургалтын явц

3. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн дэргэдэх Эрдмийн сургуулийн Анагаах ухааны эрхзүй ба боловсрол судлалын тэнхимийн багш, хуульч, өмгөөлөгч Э.Ганбаттай хамтран "Мэргэжлийн ёс зүй ба анагаах ухааны эрхзүй" сэдэвт 1 кредитийн сургалтыг 2024.01.23-нд тус эмнэлгийн удирдах албан тушаалтан, тасгийн эрхлэгч, их эмч нарт амжилттай зохион байгууллаа.



Зураг. Сургалтын явц

4. 2024.02.24-ний өдөр Улсын нэгдүгээр төв эмнэлгийн "Удирдах ажилтны



Зураг. Сургалтын явц

Долоо. Хоол үйлдвэрлэлийг сайжруулах ажлын хүрээнд:

УНТЭ-ийн хоол эмчилгээний үр дүнд эмнэлзүйн хоол зүйч доорх чиглэлээр 2024.12.02-2024.12.08 хооронд хяналт үнэлгээ хийж ажилласан. Үүнд:

1. ЭМС-ын A/440 “Эмнэлзүйн хоол эмчилгээний заавар” дагуу эмчилгээний хоолны ангилал, нэр төрөл
2. Эмчилгээний хоолны ангилалд тохирох илчлэг, шимт бодисын хэмжээ жишиг хэмжээг хангаж буй эсэхэд тооцооны аргаар үнэлгээ хийх
3. Иж бүрдэл эмчилгээний хоолны хүнсний бүлэг, бүтээгдэхүүний нэр төрлийн агууламж

ЭМС-ын A/440 “Эмнэлзүйн хоол эмчилгээний заавар” дагуу эмчилгээний хоолны ангилал, нэр төрөл

УНТЭ-т хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчидэд эмчилгээний хоолыг ЭМС-ын 2023 оны A/440 тоот тушаалын эмчилгээний хоолны нэршил дагуу түүнд тохирсон шимт бодисыг агуулсан хоолоор үйлчилдэг. Зураг 1-т эмчилгээний хоолны ангилал, нэршилийн E-Health дээр харагдах байдлыг үзүүлсэн.

Төрөл	Бичигтэйгээр нэрлэгдсэн хоол	Эмчилгээний хоол	Хүнсний бүлэг	Тухайн бүлэг	Хоолны нэршил	Хоолны нэршил
1	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
2	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
3	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
4	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
5	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
6	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
7	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
8	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
9	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
10	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
11	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
12	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
13	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
14	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
15	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
16	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
17	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
18	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
19	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал
20	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал	Хоолны ангилал

Зураг 1. Эмчилгээний хоолны ангилал, нэршил

Хоолны мэдээг дээрх нэршилийн дагуу хэвтэн эмчлүүлэх тасгуудаас нэгтгэгдсэн байдлаар хоол үйлдвэрлэлийн тасагт ирдэг.

Эмчилгээний хоолны ангилалд тохирох илчлэг, шимт бодисын хэмжээ жишиг хэмжээг хангаж буй эсэх

УНТЭ нь үйлчлүүлэгчидэд өвчний оношоос хамааран өдөрт 3-5 удаагийн эмчилгээний хоолоор үйлчилдэг. Эмчилгээний хоолны ангилалд тохирох илчлэг, шимт бодисыг батлагдсан хоолны цэс, технологи картыг ашиглан тооцооны аргаар тооцоолж эмчилгээний хоолны жишиг хэмжээтэй харьцуулан хүснэгт 1-д үзүүлсэн.

Иж бүрдэл эмчилгээний хоолны хүнсний бүлэг, бүтээгдэхүүний нэр төрлийн агууламж

Иж бүрдэл хоолонд 1-р хоол, 2-р хоол, хачир, жимс гэсэн байдлаар өдрийн туршид 6 бүлэг хүнсний бүтээгдэхүүнийг агуулсан эмчилгээний хоолоор үйлчилж байна. Хүснэгт 2-т эмчилгээний хоолыг 7 хоногийн өдөр тус бүрээр үзүүлэв

Эмчилгээний хоолны хяналт, үнэлгээний үр дүнд доорх дүгнэлт гарсан. Үүнд:

1. ЭМС-ын А/440 "Эмнэлзүйн хоол эмчилгээний заавар" дагуу эмчилгээний хоолны ангилалын дагуу эмчилгээний хоолны мэдээг авч үйлчлүүлэгчидэд олгож байна.
2. Эмчилгээний хоолны ангилалд тохирох илчлэг, шимт бодисын хэмжээг тооцооны аргаар тооцоолоход жишиг хэмжээг хангасан байна. Эмчилгээний хоолонд ашиглаж буй хоолны цэс, технологи карт нь зааврын дагуу батлагдаж хоол үйлдвэрлэлд ашиглагдаж байна.
3. Иж бүрдэл эмчилгээний хоолонд агуулагдах хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл хүнсний 6 бүлгийг зөвлөмж хэмжээнд агуулсан найрлага бүхий хоол үйлчлүүлэгчдэд олгож байна.

Тайлан бичсэн: Чанарын мэдээллийн асуудал

хариуцсан мэргэжилтэн



С.Гэрэлчимэг

Хянасан:

ЭМТҮЧАБА-ны дарга



М.Одсүрэн